

58
187

“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2014.04.30

№01

Улаанбаатар

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 15⁰⁰ цагт “Корпорейт зочид буудал” ХХК-ийн хурлын танхимд эхэлж 17⁰⁰ цагт дуусав.

Хурлын эхэнд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдсон хийгдэх ажил, цаг хугацааны графикчилсан төлөвлөгөөний гүйцэтгэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Батсуурь танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирсэн саналын хуудсаар хуралд оролцогчдын ирцийг тооллогын комисс нэгтгэн гаргалаа.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт 10.231.389 ширхэг энгийн хувьцаанаас 10.170.242 ширхэг саналын эрхтэй хувьцааг төлөөлж 8.238.692 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 81.9 хувь нь хуралд ирсэн учир хурлын ирцийг хангалттай гэж үзэж байгаа гээд уг хуралд санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан тайлбар өгөн, тооллогын комиссын мэдээллийг тооллогын комиссын дарга уншиж сонсгоод хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье гэв.

Хурал нээж, хурлын дарга Б.Батмөнх үг хэлж, хуралд хэлэлцэх асуудал, хурлын дотоод журмыг танилцуулав.

Б.Батмөнх – Компанийн ТУЗ-ийн хурлаас, хурлын даргаар намайг томилсон.

Хурлын эхэнд ХЭ-ийн хуралтай холбогдон хийх ажлын цаг хугацааны графикчилсан төлөвлөгөөний гүйцэтгэлийг дэлгэрэнгүй танилцууллаа.

ТУЗ-ийн хурлаар томилсон тооллогын комисс, энэхүү хурлын ирцийг гаргаж мэдээллээ.

Хурлын ирц хангалттай байгаа тул хурлын үйл ажиллагааг нээж байна гэв.

Өнөөдрийн хуралд хэлэлцэх асуудал дотоод журмын талаар болон тайлан, хурлаас гарах шийдвэрийн төсөл зэрэг бүх материалыг товхимол болгон 3 дугаар сарын 21-нээс манай хувьцаа байгаа бүх брокер диллерийн компаниудаар дамжуулан тараасан. Хэвлэл мэдээлэл, вэб сайтад байрлуулан урьдчилан танилцах боломжийг бүрдүүлсэн гэв.

Өнөөдрийн хуралд дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан /тогтоол гарна/
2. Компанийн ТУЗ-ийн 2014 оны цалин урамшуулал, зардлын төсөв /тогтоол гарна/
3. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулна /хурлын тэмдэглэл/

Хурлын дотоод журам /дэг/-ийг асуудал бүрээр төлөвлөж 2 цагт багтаана гэв.

Уг асуудлаар өөр санал гараагүй учир хуралд оролцогчид батлав.

118-59
11

1.ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан”

Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайлан, 2014 оны зорилтын талаар Ерөнхий инженер Ж.Эрдэнэбат, санхүүгийн тайлангийн талаар ахлах эдийн засагч Л.Оюундарь, ТУЗ-ийн тайлан дүгнэлтийн талаар ТУЗ-ийн дарга Б.Батмөнх нар проектор ашиглан тайлбарлан танилцуулав. /материалыг хавсаргав/

Б.Батмөнх – Хуралд хэлэлцэх асуудлаа танилцуулж дуусаад асууж тодруулах зүйлээ асууж, санал бодлоо ярилцвал ямар вэ? гэв.

Хуралд оролцогчид уг саналыг дэмжлээ.

2.ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2014 оны цалин урамшуулал, болон зардлын төсөв”

Уг төсөвийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Батсуурь уншиж танилцуулав. /материалыг хавсаргав/

3.ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэр”

Ногдол ашиг хуваарилахгүй болсон шалтгааны талаар ахлах эдийн засагч Л.Оюундарь танилцуулав.

Л.Оюундарь – Өнгөрсөн онд компанийн тухай хуулийн 76.1.12-р заалт, компанийн дүрмийн 12-р бүлгийн заалт, ТУЗ-ийн хурлын шийдвэрээр нэгж хувьцаанд 50 төгрөгөөр тооцож 2012 оны цэвэр ашгийн 27,1%-ийг ногдол ашиг болгон хуваарилсан.

Үүнээс 508,5¹ сая төгрөгийг “ҮЦТТХТөв”-өөр зуучлуулан болон компани өөрөө тараасан. 2013 оны ногдол ашиг тараахгүй шалтгаан нь:

1. Тус компанийн “Ня-бо бүртгэлийн бодлого, горим”-ын 4.9.1-р заалтын дагуу “Ирээдүйд үр ашиг авч ирэхэд чиглэгдсэн удаан хугацаанд ашиглагдах хөрөнгийг бүрдүүлэх зардлууд байна” гэсэн заалтын дагуу 2.297,0 сая төгрөгний хөрс хуулалтын зардлыг капиталжуулсан.
2. 2014 онд нүүрс олборлолт хөрс хуулалтыг нэмэгдүүлэхийн тулд тоног төхөөрөмжийн шинэчлэл зайлшгүй хийх шаардлагатай. Нүүрс угаах үйлдвэр, түүний дэд бүтцийг худалдан авах угсрах ажлыг санхүүжүүлэх зорилгоор 2014 онд ЕСБХ Банкнаас 10,0 сая ам.доллар, Файрберд сангаас 5,0 сая ам.долларын зээл авахаар гэрээ хэлцэл хийгдэж байна.
3. 2013 оны эцсээр компани 11.095,8 сая төгрөгийн авлагатай, 21.347,6 сая төгрөгийн өглөгтэй. Өглөг нь авлагаасаа 10.251,8 сая төгрөгөөр давсан.
4. Цаашид дараагийн жилүүдийн бэлэн нүүрсний нөөц бий болгох зорилгоор хөрс хуулалтын ажлыг түлхүү хийгдэнэ. Хөрс хуулалтын зардалд их хэмжээний хөрөнгө шаардлагатай байдаг.
Ийм шалтгаанаар ногдол ашиг хуваарилах боломжгүй гэж ТУЗ шийдвэр гаргасан байна гэв.

Б.Батмөнх – Хуралд танилцуулах асуудал дууслаа. Хэлэлцэж буй асуудалтай холбогдох асуулт, санал дүгнэлт гаргаж болно гэв.

Цэрэнжав /хувьцаа эзэмшигч/ - Энэ янзаар бол бид ойрын жилүүдэд ногдол ашиг авахгүй юм байна. Ийм их зээл аваад байхын оронд нэмэлт хувьцаа гаргаж болохгүй байсан уу. “Нако түлш” компанийг заавал авах хэрэгтэй юм уу. МХБ-д бүртгэлтэй компани биз дээ.

Б.Батмөнх – 2012 онд бид сайн ажилласан. Ногдол ашиг хуваарилсан. 2013 онд ч муугүй ажиллаа. Нүүрс олборлолтын хэмжээ нэмэгдсэн ч хөрөнгө оруулалт эрс нэмэгдсэн.

Цаашид ч нэг хэсэг, хөл дээрээ бостол хөрөнгө оруулалтын зардал өснө.

Бүх техник тоног төхөөрөмжийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай. Ингэж байж бид олон улсын стандартад хүрсэн, нийцсэн техник технологитой орчин үеийн уурхай болох хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Шинэ карьер нээх ажил урт нэртэй хуулиас шалтгаалан хүлээгдэж байна.

Бид 2010, 2011 онд нэмэлт хувьцаа гаргаж хөрөнгө босгоод геологи хайгуулын ажил хийж нөөцөө шинэчлэн тогтоосон. Энэ нь хамгийн чухал гол асуудал байсан. Бага биш баталгаат нөөцтэй болсон.

Дахин нэмэлт хувьцаа гаргахыг зөвшөөрөхгүй, бас хувьцаа худалдаалагдахгүй шалтгаан бий. Зээл авахаас өөр аргагүй. Гэхдээ байгаль орчинд сөрөг нөлөөтэй учир нүүрсний уурхай, цахилгаан станцад зээл олгодоггүй юм. Харин олон сар явж, ярьж хөөцөлдөж байж зээл авахаар болсон. ХААН банкнаас урьдчилгаа зээл авсан. Одоо авах зээлээсээ түүнийг төлөх учиртай. НАКО-г болон угаах үйлдвэрийг авснаар байгальд ээлтэй шинэ бүтээгдэхүүн гаргаж алсдаа гадаад зах зээлд гаргах зорилт бий.

Цэрэнжав /хувьцаа эзэмшигч/ – “Эрнест энд Янг аудит” нь “Зоос” банкыг дампууруулсан. “Шарын гол” ХК-ыг дампууруулчих юм биш биз.

Г.Мөнх-Эрдэнэ /хувьцаа эзэмшигч/ - Тайланг тодорхой биш байна гэж үзэж байна. Хөрөнгө оруулалт хийгээд 70 хувийн борлуулалт хийсэн нь зах зээлгүй болсонтой холбоотой гэж үзэх үү.

Б.Батмөнх – Тайланг батлагдсан загвар, хууль дүрмийн дагуу тодорхой бөгөөд бусдад ойлгогдохоор бичиж, уншиж танилцах боломжийн цаг хугацаагаар харьяа БДК-ууд, вэб сайт, сонин хэвлэлээр мэдэгдэж тараадаг нээлттэй компани.

Манай нүүрсний зах зээл хангалттай байгаа. Дархан, Эрдэнэтийн чиглэлийн үйлдвэрлэлийн бүс, цахилгаан станц, барилгын материал, төмөрлөгийн үйлдвэр гээд цаашид өсөж хөгжих районд байрлалтайгаараа бид давуу. Цаашдаа нүүрсээ угаах, хагас коксжуулан утаагүй түлш үйлдвэрлэн зах зээлд, бүр гадагшаа гаргах зорилготой.

Би эрчим хүчний яамны зөвлөлийн багт ажилладаг. Эрчим хүчний салбарт нүүрсний эргэлт улам өснө.

2015, 2016 оноос манай компани илүү ашигтай ажиллаж эхлэх үед өнөөдрийн зээл, их зээл биш болно. Гагцхүү үйл ажиллагаагаа тогтвортой, өсөлттэй явуулж үр дүнд хүргэх хугацаа хэрэгтэй.

Уналтын уурхайг босгож дэлхийн жишигт хүргэхэд тодорхой хугацаа, хөрөнгө, хүч хэрэгтэй шүү дээ.

Г.Мөнх-Эрдэнэ /хувьцаа эзэмшигч/ – Санхүүгийн тайланд мөнгөн урсгалын тайлан харагдахгүй байна.

Б.Батмөнх – Санхүүгийн тайланг бүрэн хэмжээгээр СЗХ, МХБ-д хүргүүлж вэб сайтад байрлуулдаг. Мөн “Өдрийн сонин”-д хэвлүүлдэг. Улаанбаатар оффист ч ирж танилцах боломжтой. Нээлттэй байгаа.

Энхтуяа /хувьцаа эзэмшигч/ - Ногдол ашиг олгохгүй гэсэн ТУЗ-ийн хурлын тогтоолын үндэслэлд дээрхи мэдээлэлд дурьдсан зүйлийг тусгах байсан. Хөрс хуулалтын коэффициент гэж бичсэнийг ойлгохгүй байгаа.

Л.Оюундарь – Уг тогтоолын үндэслэлд, ногдол ашиг олгохгүй шалтгааныг хураангуйгаар бүрэн тусгасан байгаа. Хуулах хөрс, олборлох нүүрсний харьцааг хөрс хуулалтын коэффициент гэх бөгөөд 1 тн нүүрс олборлоход ногдох хөрсний хэмжээ ихэсч байгаа гэсэн үг гэж тайлбарлав.

Б.Батмөнх – Зээл ихтэй байхад ашиг хуваарилах боломжгүйг ойлгох хэрэгтэй. Зээлээр хөрөнгө оруулалт хийж үйлдвэрлэлээ нэмэгдүүлээд ашигтай ажиллах үед аяндаа ногдол ашиг олгох болно.

Одбаяр /хувьцаа эзэмшигч/ - Нүүрс угаах үйлдвэр бүрэн хүчин чадлаараа хэдийд ажиллах вэ?

Б.Батмөнх – Угаах үйлдвэрийн зарим хэсэг нь арай ирээгүй байна. Угсралтын ажил 8 сард эхэлж 9 сараас нүүрсээ угааж гаргаж эхэлнэ. Аль болох цаг хожих бодолтой байна. Жилдээ 600,0 мян тонн нүүрс угаах чадалтай. Угаасан нүүрсээ бид шаардлагатай зах зээлд гаргана.

Өөр асуулт асуух, ярих хүнгүй учир тооллогын комиссын дүнг бэлэн болтол завсарлав. Хурал 15 минут завсарласны дараа үргэлжлэв.

Тооллогын комиссын даргаар ажилласан Л.Эрхбаатар тооллогын комиссын дүн, тогтоолыг танилцуулав. Үүнд: нийт 8.328.692 ширхэг энгийн хувьцаа бүхий саналын 19 хуудас ирсэн бөгөөд үүнээс 2817 ширхэг энгийн хувьцаа бүхий саналын 1 хуудасны санал өгсөн тоо нь зөрүүтэй байснаас хүчингүй болсон. 8.325.875 ширхэг хувьцааны санал хүчинтэй байсан.

Тус хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудал тус бүрээр завшаарсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, хувь, тогтоол дугаар 1,2-ыг танилцуулав.

/ХЭХ-д ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн саналын товчоог хавсаргав/

Тооллогын комиссын тогтоолыг хурлын даргад өгөв. Тооллогын комиссын тогтоолоос асууж танилцах зүйл гарсангүй.

/Тооллогын комиссын тогтоол, саналын хуудасны хуулбарыг хавсаргав/

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах доорхи тогтоолын төслийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Батсуурь уншиж сонсгов.

Үүнд:

1. “Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайлангийн тухай” тогтоол дугаар 01
2. “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны зардлын төсвийн тухай” тогтоол дугаар 02 эдгээр болно.

/Тогтоол дугаар 01, 02-ыг хавсаргав/

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тогтоолуудаас асууж тодруулах зүйл байгаа эсэхийг хурал даргалагч Б.Батмөнх асуухад асуулт гарсангүй, хуралд оролцогчдын 100 хувийн саналаар батлав.

Хурлын үйл ажиллагааг хурлын дарга Б.Батмөнх хааж, товч үг хэлснээр хурлын ажиллагаа өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн: Нарийн бичгийн дарга  Л.Батсуурь
Танилцсан: Хурлын дарга  Б.Батмөнх

